



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН
АЧААЛЛЫН ТАЛААРХ ГАДААД УЛС
ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч:

Дотоод хэргийн их сургууль

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

С.Сүхбаатар

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэмтэн
нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Г.Халиунаа

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

Удиртгал	4
Нэг. Олон улсын жишиг стандарт байдаг эсэх, холбогдох олон улсын байгууллагаас хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын талаар	5
Хоёр. Монгол Улс /цаашид “МУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт	8
Гурав. Бүгд Найрамдах Солонгос Улс /цаашид “БНСУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт	10
Дөрөв. Америкийн Нэгдсэн Улс /цаашид “АНУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт	12
Тав. Оросын Холбооны Улс /цаашид “ОХУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт	16
Зургаа. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /цаашид “ИБУИНВУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт	17
Дүгнэлт	21
Ашигласан эх сурвалж.....	22

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллын талаарх гадаад улс орнуудын харьцуулсан судалгаа¹

Удиртгал

Манай улсад сүүлийн жилүүдэд цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллын талаар нэлээдгүй яригдах болсон. Ялангуяа цар тахалтай өнөөгийн нөхцөлд цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал энгийн үеийнхээс хэд дахин нэмэгдэж байгаа талаар яригдсаар байгаа юм. Ер нь цар тахал төдийгүй энгийн үед манай улсын цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал их байдаг нь судалгаа тоо баримтаас харагддаг. Тухайлбал, манай улсын хувьд 4000 хүнд нэг хэсгийн байцаагчийн орон тоотойгоор ажиллах жишиг нормативыг 2011 оны Засгийн газрын 153 дугаар тогтоолоор баталсан байдаг. Засгийн газрын 2020 оны 141 дугаартай тогтоолоор баталсан Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт "...улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагын одоогийн бүтэц, орон тоо, ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн тоо энэхүү жишиг нормативт хүрэхгүй, 4000 орчим орон тоогоор бага байгаа нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрх зөрчигдөх, эрүүл мэндээр хохирох нөхцөлийг бий болгож байгаа талаар Хүний эрхийн үндэсний комиссоос Улсын Их Хуралд хүргүүлсэн "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд дурдсан байдаг."² гэж тусгажээ. Мөн энэ талаар холбогдох албаны хүмүүс байр суурь илэрхийлдэг.³

Бразил Улсад 2010 онд зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон эрүүгийн хэрэг шүүн таслах асуудлаарх 12 дугаар конгресс дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын Олон улсын эрүүгийн нөхцөл байдал, шүүн таслах ажиллагааны талаарх илтгэлд "Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2006 онд дэлхийн 142 орны хууль сахиулах байгууллагыг хамруулан хийсэн хүн хүчний талаарх судалгаагаар 100.000 хүн ам тутамд дунджаар цагдаагийн 300 алба хаагч ногддог. Дээрх тоо улс орон бүрт харилцан адилгүй байгаа ба зөвхөн 4 улсад 100.000 хүн ам тутамд 100-аас бага, Баруун Ази, Зүүн болон Өмнөд Европын зарим улс орнуудад харьцангуй өндөр (400 орчим) тооны цагдаагийн алба хаагч ногдож байна гэжээ."⁴

Түүнчлэн Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт "Монгол Улсын хувьд нэг алба хаагчид ногдох хүн амын тоо 371 байгаа нь дэлхийн бусад орны дундаж түвшингээс их ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна. Мөн гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдын ажлын ачаалал их байгаагаас долоо хоногт 70 хүртэлх цагаар ажиллаж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан 40 цаг ажиллахаас даруй 75.0 хувиар илүү байна. Тухайлбал, "Ажиглалт" төрийн бус байгууллагаас 2018 онд хийсэн "Цагдаагийн байгууллагын зарим ажлын байрны ачааллыг тооцох судалгаа"-гаар 9 ахлах мөрдөгч тутамд 2, 9 мөрдөгч

¹ Энэхүү харьцуулсан судалгааг ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгээс гүйцэтгэж буй "Цагдаагийн албан хаагчийн ажил үүргийн онцлог-эрүүл мэндэд үзүүлж буй нөлөө" сэдэвт судалгааны хүрээнд ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс 22-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

² Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 141 дугаартай тогтоолын хавсралт "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр", <https://www.legalinfo.mn/annex/details/11003?lawid=15324>

³ "Гэмт хэргийг багасгая гэвэл цагдаагийнхаа тоог нэмэх ёстой" (нийтлэгч Х.Батсайхан), 2019.04.30 <http://eagle.mn/r/58732>

⁴ Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 141 дугаартай тогтоолын хавсралт "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр", <https://www.legalinfo.mn/annex/details/11003?lawid=15324>

тутамд 2, 11 замын цагдаагийн зохицуулагч тутамд 1, 6 цагдаагийн зохицуулагч тутамд 1, 3 хэсгийн байцаагч тутамд 2, 4 хэсгийн төлөөлөгч тутамд 2, 5 хэрэг бүртгэгч тутамд 2 ажлын байр нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагатай гэсэн дүгнэлт, зөвлөмж гарсан”⁵ талаар дурдсан байна.

Иймд тухайн асуудалд бодит дүгнэлт өгөхийн тулд гадаадын зарим улсын жишээг өөрийн улсын цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал, хуваарилалтын түвшинтэй харьцуулан жишиж үзэх шаардлага үүсч байна. Энэ хүрээнд бид олон улсын жишиг нэгдсэн стандарт байгаа эсэхийг тодруулан авч үзэхийг зорьсноос гадна, өөр өөр эрх зүйн бүлд хамаардаг, гэмт хэргийн гаралт өндөртөйд тооцогддог Америкийн Нэгдсэн Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсыг сонгон судаллаа.

Энэхүү харьцуулсан судалгаа нь цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт, түүнийг журамласан байдлын талаар гадаад орны туршлага судлах зорилготой бөгөөд судалгаанд ашигласан эх сурвалжуудад Монгол Улсын адил эрх бүхий байгууллагаас норм, стандарт хараахан батлан гаргаагүй байна.

Иймд судлаачдын зүгээс судалгааны хүрээнд сонгон авсан гадаадын зарим орны цагдаагийн байгууллагын бүтэц, тухайн улсын (газар нутгийн) хүн амын тоог цагдаагийн нийт алба хаагчдын тоонд харьцуулан гаргахыг зорилоо.

Нэг. Олон улсын жишиг стандарт байдаг эсэх, холбогдох олон улсын байгууллагаас хийгдсэн судалгаа шинжилгээний ажлын талаар

Олон улсын түвшинд нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын талаар нэгдсэн стандарт бий болгосон эсэхийг олон улсын хамаарал бүхий байгууллага⁶ болох Олон улсын цагдаагийн холбоо (International Police Association), Олон улсын хот төлөвлөлтийн холбоо (International city/county management association), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх алба (United nations office on drug and crime) зэрэг байгууллагын мэдээллээс авч үзэхэд цагдаагийн алба хаагчийг хуваарилах талаар холбогдох судалгаа, шинжилгээний ажил хийгдсэн байдаг байна. Энэхүү судалгааны тайлан болоод эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаар товчхон авч үзье.

Олон улсын цагдаагийн холбоо (International Police Association):⁷ цагдаагийн алба хаагчдын ажил эрхэлдэг эсвэл тэтгэвэрт гарсан эсэхээс үл хамааран албан тушаал, хүйс, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг ялгаваргүй хамаарч болох байгууллага юм. 100 шахам улс оронд 372,000 орчим гишүүнтэй бөгөөд үүнээс 65 харьяа байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тус байгууллага нь цагдаагийн алба хаагчдын хоорондох найрамдалт холбоог бий болгох, бэхжүүлэх, нийгэм, соёл, мэргэжлийн салбарт олон улсын хамтын ажиллагааг дэмжих, ард түмний хооронд энх тайвнаар зэрэгцэн орших, дэлхийн энх тайвныг хадгалан хамгаалах, цагдаагийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус байгууллага нь жил бүр гарын авлага, сэтгүүл, танилцуулга, зөвлөмж зэргийг гаргадаг байна.

⁵ Мөн тэнд

⁶ Эдгээр байгууллагын үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллага, алба хаагчдад чиглэгддэг.

⁷ International Police Association:Publication <https://www.ipa-international.org/National-IPA-Publications>

Олон улсын хот төлөвлөлтийн холбоо (International city/county management association ICMA):⁸ тус байгууллага нь 11000 гаруй гишүүдтэй бөгөөд оршин суугчдын амьдралыг сайжруулах зорилгоор орон нутгийн төлөвлөлтийн тэргүүлэх туршлагыг олж тогтоох, нэвтрүүлэх ажлын хүрээнд дэлхийн олон мянган хот, тосгон, мужийн захиргааны удирдлагууд, ажилтнуудад мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр хэргжүүлдэгээс гадна, сургалт, судалгаа, мэдээлэл, техникийн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Тус байгууллага цагдаагийн дарга болон менежерийн харилцаа холбоо, хотын цагдаагийн газрыг хэрхэн нийгэмтэй уялдуулах талаар хэд хэдэн судалгаа хийсэн бөгөөд бидний судалгааны сэдвийн хүрээнд судлагдаж буй цагдаагийн алба хаагчийн хуваарилалт хийх арга замын талаар судалж 5 загвар байгаа талаар дурджээ.⁹ Эдгээр загварын талаар товчхон авч үзье.

1. Гэмт хэргийн чиг хандлагаар хуваарилах арга

20 дугаар зууны эхэн үед цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа болон мэргэшсэн түвшинг гэмт хэргийн гаралтын бууралтын түвшингээр тодорхойлдог байсан. Ерөнхийдөө гэмт хэргийн үзүүлэлтийг цагдаагийн алба хаагчийн ажил эрхлэлт, хүний нөөцтэй холбодог байжээ. Гэхдээ бодит байдал дээр энэ арга нь үр ашиггүй байсан. Учир нь цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үр дүнгүй хийсэн тохиолдолд дахин нэмж цагдаагийн алба хаагчийг томилох замаар ачааллыг бууруулахад чиглэж байсан. Гэтэл гэмт хэргийн гаралтад цагдаагийн алба хаагчийн нөөцөөс өөр олон хүчин зүйл нөлөөлдөг. Тиймээс цагдаагийн алба хаагчийн хуваарилалтыг хийхдээ гэмт хэргийн гаралтын түвшинг харгалзах нь оновчтой зохицуулалт биш бөгөөд одоо үед ховорхон хэрэглэдэг болжээ.

2. Нэг хүнд ногдох цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын арга

Ерөнхийдөө энэхүү арга нь цагдаагийн алба хаагчийн тоог нэг хүнд ногдох харьцаагаар илэрхийлэх арга юм. Тухайн улс орны хүн амын тоо болон цагдаагийн байгууллагын харьцааг тодорхойлж зохих орон тоог бий болгоно гэсэн үг юм. Олон улсын цагдаагийн дарга нарын холбооноос энэ аргыг хэрэглэхийг зөвлөдөггүй ч энэ талаар “Хэтийн төлөв” сэтгүүлдээ нийтэлж, судалсан байна. 1000 оршин суугчид ногдох цагдаагийн алба хаагчийн дундаж харьцааг тайлагнасан 2003 оны BJS судалгаанд 1000 оршин суугчид ногдох орон тооны алба хаагчдын харьцаа 2.6-аас 1.8-д хэлбэлзэж байсан байна. Гэхдээ энэ нь арга хэт ерөнхий байдаг тул энэхүү аргыг үр ашиггүй, найдвартай биш гэж үздэг.

3. Хамгийн бага ажиллах хүчний түвшингээр хуваарилах арга

Энэхүү арга нь практик, бодлого, хяналтад суурилсан арга бөгөөд ээлж бүрээр ажиллах ажилчдын тоог тогтооход ашигладаг. Хатуу болон зөөлөн байдлаар ажиллах хүчний түвшинг хуваарилдаг. Ингэж хуваарилахыг менежментийн агуулгын нэг хэсэг болгон өөрчлөхөд хүндрэлтэй.

4. Төсөв болон эрх олголтод суурилсан хуваарилалтын арга

Энэ арга замаар хот, суурин газар нь орон нутгийн төсөвт тохирсон тодорхой түвшний боловсон хүчнийг урьдчилан тодорхойлдог. Үндсэндээ энэ бол "Би юу авч чадах вэ?" гэх

⁸ 5 Police resources from ICMA <https://icma.org/blog-posts/5-police-resources-icma>

⁹ An analysis of police department staffing: How many officers do you really need? A Review of 62 Police Agencies Analyzed by the ICMA / CPSM
https://icma.org/sites/default/files/305747_Analysis%20of%20Police%20Department%20Staffing%20_%20McCabe.pdf?fbclid=IwAR35Z1jtlKm37ybHYdiuSFJomGvpzxHmeDPuHHA5BweS7ALspwfl8bdofwg

үзэлд суурилсан олон нийтийн бодит хэрэгцээнд тулгуурласан загвараас ялгаатай загвар. Мөн энэ нь цагдаагийн боловсон хүчний асуудалд нэлээд нийтлэг хандлага бөгөөд боловсон хүчний түвшинг тодорхойлох асуудлыг олон нийтийн төсөв боловсруулах үйл явцад чиглүүлдэг. Тухайлбал, өмнөх жилийн төсвийг санхүүгийн өнөөгийн байдалтай уялдуулан шалгаж, боловсон хүчний шийдвэр гаргадаг.

5. Бодит ажлын ачаалалд суурилсан хуваарилалтын арга

Хамгийн бага хэрэглэгддэг арга нь бодит ажлын ачаалалд суурилсан арга юм. Энэ арга нь цагдаагийн байгууллагын үйлчилгээний бодит эрэлт хэрэгцээг цагдаагийн алба хаагчийн нөөцийн хангамжтай нийцүүлж байгаа тул энэ аргыг Олон улсын хот төлөвлөлтийн холбоо хүчтэй сурталчлан ажилладаг. Ихэнхдээ энэ арга нь хэлтсийн хүлээн авсан үйлчилгээний дуудлагыг шалгахад үндэслэдэг бөгөөд эдгээр дуудлага нь эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлоход загварчлагдсан байдаг. Энэхүү арга нь 911 дуудлагын зөвхөн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж, хэлтэст тавьсан олон нийтийн бусад шаардлагыг үл тоомсорлодог дутагдалтай талуудтай. Эдгээр дутагдлыг арилгахын тулд дээрх дуудлагын эрэлт хэрэгцээнд нийцсэн аргыг ашиглаж, дараа нь хэлтэст тулгамдаж буй бусад үйл ажиллагааны шаардлагуудтай уялдуулж зохицуулдаг. Үүний үр дүнд хэлтэс дээр байрлуулсан үйлчилгээний болон бусад тогтвортой ажиллагааны үр дүнгийн аль алинаар нь ажлын ачааллыг цогцоор нь үнэлэх явдал юм. Гэхдээ энэ хандлага нь олон цагдаагийн хэлтсийн багтаамжаас давсан мэдээллийн цогц системийг шаарддаг боловч цагдаагийн алба хаагчийн хуваарилалт, орон тоог хамгийн зөв, найдвартай таамаглаж өгдөг.

Дээрх аргуудаар цагдаагийн алба хаагчийн хуваарилалтыг хийхийн тулд дараах үзүүлэлтүүдийг харуулсан мэдээллийн бааз хэрэг болно.

- Хүн ам;
- 100.000 хүн амд ногдох цагдаагийн алба хаагч;
- Эргүүлийн цагдаагийн эзлэх хувь;
- 10.000 хүн амд ногдох гэмт хэргийн индекс;
- Хүч хэрэглэсэн гэмт хэргийн түвшин;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн түвшин;
- Цагдаад дуудлага өгсөн түвшин;
- Цагдаад өгсөн дуудлагад үйлчилсэн дундаж хугацаа;
- Цагдаад өгсөн дуудлагыг хүлээн авах нэгжүүд;
- Цагдаад өгсөн дуудлагад үйлчилсэн нийт хугацаа;
- Өвлийн болон зуны цагийн ажлын ачаалал.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх алба (United nations office on drug and crime):¹⁰ НҮБ-ын гишүүн орнуудад авлига, хүн худалдаалах, хууль бусаар хил нэвтрүүлэх, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, хар тамхины наймаа, терроризмтой тэмцэх чиглэлээр НҮБ-ын гишүүн орнуудад туслах чиг үүрэгтэй. UNODC нь улс дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын конвенцыг соёрхон батлах, хэрэгжүүлэхэд нь туслах (авлига, хүний наймаа, хар тамхины наймаа, мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, арчлах, терроризм), хүний нөөцийн мэдлэг чадварыг хөгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн эрх

¹⁰ Searched for 'Police' , <https://www.unodc.org/unodc/site-search.html?q=Police>

зүйн шинэчлэл, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх судалгаа, шинжилгээ хийх, техникийн хамтын ажиллагааны төслүүд хэрэгжүүлэх, мансууруулах бодис үйлдвэрлэх эсвэл хэрэглэхээс хамаарлыг бууруулах зорилготой эрүүл мэнд, амьжиргааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Хоёр. Монгол Улс /цаашид “МУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт

МУ-ын хувьд Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоог зохицуулдаг. Цагдаагийн албаны тухай хууль нь МУ-ын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход¹¹ чиглэгдсэн 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан хууль юм. Тус хуулийн 6.1-д зааснаар цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас бүрддэг. Мөн хуулийн 6.2 болон 7.1-д зааснаар цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоог цагдаагийн төв байгууллагын дарга тус тус баталдаг байна. Ийнхүү хуулиар цагдаагийн албаны талаар ерөнхий зохицуулалт тусгасан бөгөөд уг зохицуулалтын дагуу 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” Засгийн газрын 76 дугаар тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын удирдлагын орон тоог дарга 1, тэргүүн дэд дарга 1, дэд дарга 2 байхаар Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг дараах байдлаар баталсан.¹² Үүнд:

- Эрүүгийн цагдаагийн алба;
- Мөрдөн байцаах алба;
- Хэрэг бүртгэх алба;
- Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба;
- Тээврийн цагдаагийн алба;
- Санхүү, аж ахуйн алба;
- Захиргааны удирдлагын газар;
- Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба;
- Интерполын үндэсний төв товчоо;
- Экологийн цагдаагийн алба.

Харин нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоог цагдаагийн хэлтэс хэмээх нэгжид хуваарилан зохицуулдаг ба ерөнхий зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. (Жишээ болгон Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн бүтцийг авч үзлээ)

- Төлөвлөлт зохион байгуулалтын тасаг;
- Мөрдөн байцаах тасаг;
- Эрүүгийн цагдаагийн тасаг;
- Нийтийн хэв журам хамгаалах тасаг;
- Хэрэг бүртгэх тасаг;

¹¹ Цагдаагийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017 он, №8

¹² Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 76 дугаар тогтоол, <https://www.legalinfo.mn/law/details/13078>

- Шуурхай удирдлагын тасаг.¹³

Цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны нормыг Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын хавсралт “Цагдаагийн байгууллагын зарим ажил,үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-аар зохицуулагддаг байна.¹⁴ Тус жишиг нормативд зааснаар дараах байдлаар цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг хуваарилсан:

- 100 000 хүртэл хүн ам тутамд нэг дүүргийн цагдаагийн хэлтэс;
- 50 000 хүн ам тутамд нэг дүүргийн цагдаагийн хэлтсийн харьяа цагдаагийн тасаг;
- 70 000-аас дээш хүн ам тутамд болон газар нутгийн хэмжээ, дэд бүтэц, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, зам, тээвэр, худалдаа зэрэг салбар хөгжсөн газарт нэг аймгийн цагдаагийн газар;
- 70 000 хүртэл хүн ам тутамд нэг аймгийн цагдаагийн хэлтэс;
- 25 000-аас доошгүй хүн ам тутамд болон газар нутгийн хэмжээ, дэд бүтэц, уул уурхай, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, зам, тээвэр, худалдаа зэрэг салбар хөгжсөн газарт нэг сум, сум дундын цагдаагийн хэлтэс;
- 8000-аас доошгүй хүн ам тутамд нэг сум, сум дундын цагдаагийн тасаг;
- 5000-аас доошгүй хүн ам тутамд нэг сум дахь цагдаагийн хэсэг;
- Сум болон төмөр замын зангилаа бүрт нэг хэсгийн төлөөлөгч, цагдаа (341)¹⁵;
- Нийслэлийн хороо бүрт нэг эрүүгийн төлөөлөгч, цагдаа (171)¹⁶;
- 4000 хүн ам тутамд нэг Хэсгийн байцаагч (374)¹⁷;
- 8000 хүүхэд тутамд нэг Хүүхдийн байцаагч (187)¹⁸;
- Нийслэлд 15 000 хүн ам тутамд хоёроос доошгүй хэв журмын эргүүл (100)¹⁹;
- Аймгийн төвд 5000 хүн ам тутамд нэгээс доошгүй эргүүлийн нэг чиглэлд хоёр алба хаагч;
- 350 тээврийн хэрэгсэл тутамд нэгээс доошгүй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагч;
- Орон нутаг дахь замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуух цагдаагийн хяналтын цэг 150 км тутамд нэгээс доошгүй байх;
- Хяналтын цэг тутамд хоёроос доошгүй алба хаагч үүрэг гүйцэтгэнэ;
- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий алба хаагч нийт орон тоонд эзлэх хувь 75-аас доошгүй байх;
- Цагдаагийн алба хаагчдын нийт орон тоонд эмэгтэй алба хаагчдын эзлэх хувь 8 хувиас хэтрэхгүй байх;
- 500 000-аас доошгүй хүн амтай хотод хотын цагдаагийн газар тус тус байхаар зохицуулсан.

Дээрх хуваарилалтаас үзвэл эрүүгийн төлөөлөгч, цагдаа, хэсгийн байцаагч, хүүхдийн байцаагч, хэв журмын эргүүл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба

¹³ Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэс <http://sukhbaatar-2.police.gov.mn/news/list/type/71>

¹⁴ Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2014 оны 115 дугаар тогтоол, 2020 оны 152 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.

¹⁵ Сумын болон зангилааны тоо https://www.landbridge.mn/Default.aspx?page=136&news_id=1113

¹⁶ Нийслэлийн хороодын тоо, хүн амын тоо <http://ubstat.mn/JobTables.aspx>

¹⁷ Нийслэлийн хүн амын тоо <http://ubstat.mn/JobTables.aspx>

¹⁸ Мөн тэнд

¹⁹ Мөн тэнд

хаагч, хяналтын цэгийн алба хаагчид зэрэг цагдаагийн алба хаагчдын хувьд дунджаар нэг цагдаагийн алба хаагчид ойролцоогоор 4000-8000 хүн ам ногдож байна.

МУ-д цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлтийг нийт цагдаагийн алба хаагчид (ажил үүргийн онцлогийг харгалзахгүйгээр) тооцож үзвэл:

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын цагдаагийн нийт алба хаагчийн тоо нь 10 170 байна.²⁰ Энэ нь 100.000 хүн амд²¹ 303 цагдаагийн алба хаагч, 1 цагдаагийн алба хаагчид 330 хүн ногдох үзүүлэлттэй харагдаж байна.

Гурав. Бүгд Найрамдах Солонгос Улс /цаашид “БНСУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт

БНСУ-ын Үндэсний цагдаагийн газар нь 1 дэд ерөнхий комиссар, 1 төв штаб, 9 товчоо, 10 алба, 32 хэлтэс, 1 багийн бүрэлдэхүүнтэй байдаг.²² Үүнийг нарийвчилж авч үзвэл:

Цагдаагийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд:

- Олон нийтийн аюулгүй байдлын товчоо;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын товчоо.

Мөрдөн байцаалтын чиглэлд:

- Үндэсний мөрдөн байцаалтын алба буюу Мөрдөн байцаалтын төлөвлөлт, зохицуулалтын товчоо, Шүүхийн шинжилгээний удирдлагын газар, Мөрдөн байцаах газар, Детектив товчоо, Кибер мөрдөн байцаах газар, Үндэсний аюулгүй байдлын мөрдөн байцаах газар

Нийтийн хэв журмын чиглэлд:

- Нийтийн хэв журам хамгаалах товчоо;
- Олон нийтийн энх тайван, аюулгүй байдлын алба;
- Гадаад харилцааны товчоо;

Захиргааны чиглэлд:

- Хэвлэлийн төлөөлөгчийн газар;
- Аудит, хяналт шалгалтын газар ;
- Төлөвлөлт, зохицуулалтын товчоо ;
- Цагдаагийн удирдлага, хүний нөөцийн товчоо;
- Мэдээлэл харилцаа холбоо технологи, тоног төхөөрөмжийн бодлогын газар тус тус ажиллаж байна.

Мөн үүнээс гадна 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан БНСУ-ын Үндэсний цагдаагийн болон цагдаагийн орон нутгийн байгууллагын бүтцийн тухай хуулийн 13 дугаар зүйл болон 4, 5 дугаар бүлэг буюу 18-31 дүгээр зүйлд зааснаар үүнээс гадна дараах нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага байхаар хуульчилсан байна.²³

²⁰ “Цагдаагийн алба хаагчдын 98 хувийг урамшуулна”, (нийтлэгч С.Мөнхбаатар), 2020.11.29 <https://montsame.mn/mn/read/244959>

²¹ Монгол Улсын нийт хүн ам 2021 оны 6 дугаар сарын 18-ны байдлаар 3.357.542 <https://www.1212.mn/>

²² “Organization of National Police Agency” <https://www.police.go.kr/eng/knpa/org/org02.jsp#>

²³ Act on Organization and Operation of National Police and Self-Governing Police, 2021.01.01, <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9%EA%B2%BD%EC%B0%B0%EB%B2%95>

- Хотын өөрийн удирдлагатай цагдаагийн газар;
- Метрополитан болон дүүргийн өөрийн удирдлагатай цагдаагийн газар.

БНСУ-ын цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын хувьд хуулиар тусгайлан зохицуулсан зохицуулалт байхгүй байна.²⁴

БНСУ-ын нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлтийг нийт цагдаагийн алба хаагчид (ажил үүргийн онцлогийг харгалзахгүйгээр) тооцож үзвэл:

Хүснэгт 1. БНСУ-ын нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн ам²⁵

	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он ²⁶
Цагдаагийн алба хаагч	102,386	105,357	109,364	113,077	114,658	116,584	118,651	122,913
Нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн ам	498	485	469	456	451	444	437	422
Өөрчлөлтийн үзүүлэлт	-	-2.61%	-3.3%	-2.77%	-1.1%	-1.55%	-1.58%	-3.43%
100 000 хүн амд ногдох цагдаагийн алба хаагч ²⁷	-	-	-	-	223	227	229	237
1 цагдаагийн алба хаагчид ногдох хүн ам	-	-	-	-	448	440	436	421

Тухайн тоон үзүүлэлтээс үзэхэд 2019 он хүртэл БНСУ-ын цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоо жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Цагдаагийн алба хаагчдыг албан тушаалаар нарийвчлан харвал.²⁸

Цагдаагийн алба хаагч	Тоо
Ерөнхий комиссар	1
Ерөнхий захирагч генерал	6
Ахлах захирагч генерал	27
Захирагч генерал	64
Ахлах захирагч	545
Захирагч	2706

²⁴Korean law information center

<https://www.law.go.kr/eng/engLsAstSc.do?menuId=1&dataCls=lsAstSc&lsFdCd=11000000,11010000,11020000,11030000,11030100,11030200,11030300,11030400,11040000,11050000,11060000#lsFd11000000>

²⁵ "Change of police work force and population in charge by a single police officer (Unit : no. of people)" <https://www.police.go.kr/eng/statistics/statisticsSm/statistics01.jsp>

²⁶ БНСУ-ын нийт хүн ам 2019 оны байдлаар 51,225.308

<https://www.macrotrends.net/countries/KOR/south-korea/population-growth-rate>

²⁷ Total population in South Korea from 2016-2020

<https://www.statista.com/statistics/263747/total-population-in-south-korea/>

²⁸ Human resources structure according to police rank (Unit: no. of people, 2019.12.31),

<https://www.police.go.kr/eng/statistics/statisticsSm/statistics01.jsp>

Ахлах мөрдөгч	9040
Мөрдөгч	15 853
Туслах мөрдөгч	25 049
Ахлах цагдаа	31 545
Цагдаа	37 858
Бүгд	122 913

Харин цагдаагийн төв байгууллага, цагдаагийн алба, цагдаагийн хяналтын цэгийн хуваарилалт нь Сөүл хотод хамгийн их буюу 31 цагдаагийн төв байгууллага, 96 цагдаагийн алба, 145 цагдаагийн хяналтын цэг байна. Хамгийн бага нь Жэжү хотод байх ба 3 цагдаагийн газар, 7 цагдаагийн алба, 19 цагдаагийн хяналтын цэг байна.²⁹

Дөрөв. Америкийн Нэгдсэн Улс /цаашид “АНУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт

АНУ-ын цагдаагийн байгууллага нь ерөнхийдөө хууль сахиулах байгууллага нэг бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд холбооны улс болохынхоо хувьд холбооны болон мужийн хууль сахиулах байгууллага гэсэн 2 хэсэгт хуваагдан үйл ажиллагаагаа явуулдаг байна. Эдгээр хууль сахиулах байгууллага нь дараах үйл ажиллагааг явуулдаг:³⁰

- Орон нутгийн цагдаа: Үүнд хотын, хэсгийн, тойргийн, бүсийн гэх тухайн орон нутгаас эрх мэдэл авсан цагдаа нар хамаардаг. Анхдагч зорилго нь харьяаллын хууль тогтоомжийг сахиулах, эргүүлээр хангах, орон нутгийн гэмт хэргийг шалгах үүрэгтэй.
- Мужийн цагдаа/хурдны замын эргүүл: Мужийн цагдаа нь ихэвчлэн хурдны замын эргүүл эсвэл тухайн мужид хамаарах гэмт хэргийн мөрдөн байцаалт хийх зэрэг үүргийг гүйцэтгэдэг. Мужийн цагдаа нар нь орон нутгийн цагдаа нарын ачаалал, хил хязгаараас давсан тохиолдолд мөрдөн байцаалт болон онцгой байдлын арга хэмжээнд тусалдаг.
- Тусгай харьяаллын цагдаа: Тусгай харьяаллын цагдаа нь цэцэрлэгт хүрээлэн, сургууль, тээврийн хэрэгсэл (жишээлбэл, нисэх онгоцны буудал, метро), эмнэлэг, орон сууцны удирдлага, Засгийн газрын барилга байгууламж зэрэг тодорхой байгууллага болон газар нутагт ажилладаг.
- Шериф: Шерифийн ажлын алба нь ерөнхийдөө тухайн муж улсын хуулийг тухайн муж улсад сахиулах үүргийг хүлээдэг. Эдгээр шериф нь ихэвчлэн мужийн шоронгийн үйл ажиллагааг хариуцах, шүүхийн захирамж, зарлан дуудах хуудсыг хүргүүлэх, харьяаллаас гадуур ирсэн дуудлагад хариу өгөх үүргийг гүйцэтгэдэг.

Холбооны болон мужийн хууль сахиулах байгууллагын бүтцийг дор авч үзье.

1. Холбооны хууль сахиулах байгууллагын бүтэц:

АНУ-ын Төрийн департамент (DOS)

- Дипломат аюулгүй байдлын товчоо;
- Дипломат аюулгүй байдлын алба (DSS);

АНУ-ын Сангийн яам

²⁹ Мөн тэнд

³⁰ Discover policing, “Types of Law Enforcement Agencies”, <https://www.discoverpolicing.org/explore-the-field/types-of-law-enforcement-agencies/>

- Дотоод орлогын алба, Эрүүгийн мөрдөн байцаах (IRS-CI);
- Татварын албаны төрийн сангийн ерөнхий байцаагчийн алба (TIGTA);
- Хөрөнгөтэй холбоотой асуудлыг арилгах хөтөлбөрийн тусгай байцаагчийн алба (SIGTARP);
- Цар тахлыг арилгах тусгай байцаагчийн алба (SIGPR);
- АНУ-ын хөрөнгө хамгаалагч цагдаа (USMP);
- Хар зураг, хурууны хээ хэвлэх цагдаагийн алба (BEP Police);

АНУ-ын Батлан хамгаалах яам (DOD)

- Батлан хамгаалах эрүүгийн мөрдөн байцаах алба (DCIS);
- Пентагоны хүчийг хамгаалах агентлаг;
- Батлан хамгаалах ложистикийн агентлаг Цагдаагийн газар;

Армийн департамент

- АНУ-ын армийн эрүүгийн мөрдөн байцаах хэлтэс (Army CID);
- АНУ-ын армийн цэргийн цагдаагийн корпус;
- АНУ-ын армийн эсрэг тагнуул (ACI);
- Армийн иргэний цагдаагийн газар (DACP);
- Армийн иргэний хамгаалалтын алба (DASG);

Тэнгисийн цэргийн департамент

- Тэнгисийн цэргийн эрэн сурвалжлах алба (NCIS);
- Тэнгисийн цэргийн тагнуулын цагдаагийн газар (ONI Police);
- Тэнгисийн явган цэргийн корпусын маршалын алба;
- АНУ-ын Тэнгисийн явган цэргийн корпусын эрэн сурвалжлах хэлтэс (USMC CID);
- АНУ-ын Тэнгисийн явган цэргийн корпусын иргэний цагдаа;

Агаарын департамент

- АНУ-ын Агаарын цэргийн хүчний тусгай мөрдөн байцаах газар (Airforce OSI);
- АНУ-ын Агаарын цэргийн хүчний аюулгүй байдал;
- Агаарын цэргийн цагдаагийн газар;

Үндэсний аюулгүй байдлын газар

- Үндэсний аюулгүй байдлын газрын цагдаа (NSA Police);

АНУ-ын Хууль зүйн яам (DOJ)

- Архи, тамхи, галт зэвсэг, тэсрэх бодисын товчоо (ATF);
- Хар тамхитай тэмцэх газар (1973 оноос хойш);
- Мансууруулах бодис ба аюултай мансууруулах бодисын товчоо (1968–73);
- Мансууруулах бодисын холбооны товчоо (1930–68);
- Хориглох товчоо (1927–33);
- Хар тамхи мансууруулах бодисыг хянах товчоо (1966–68);
- Холбооны мөрдөх товчоо (FBI);
- Мөрдөх товчоо (BOI) (1908–35)
- Холбооны шоронгийн товчоо (BOP);
- АНУ-ын Маршал Сервис (USMS);

АНУ-ын Дотоод хэргийн яам (USDI)

- Уугуул америкчуудын хэргийн цагдаагийн газар;
- Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах, зохион байгуулалтын товчоо;
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн цагдаа;
- АНУ-ын зогсоолын цагдаа;
- АНУ-ын Загас ба ан амьтны үйлчилгээний болон хууль сахиулах алба;

АНУ-ын Хөдөө аж ахуйн яам (USDA)

- АНУ-ын Ойн албаны хууль сахиулах, мөрдөн байцаах алба;
- Ерөнхий байцаагчийн алба;

АНУ-ын Худалдааны яам (DOC)

- Үндэсний далай ба агаар мандлын захиргааны загас агнуурын хууль сахиулах алба;

АНУ-ын Эрүүл Мэнд, Хүний Үйлчилгээний газар (HHS)

- Хүнс ба Эмийн Захиргаа (FDA);
- Хүнс ба Эмийн Захиргааны эрүүгийн мөрдөн байцаах газар;

АНУ-ын Боловсролын яам (ED)

- Ерөнхий байцаагчийн алба (OIG);

АНУ-ын ахмад дайчдын хэргийн яам (VA)

- АНУ-ын ахмад дайчдын асуудал эрхэлсэн газар цагдаагийн газар;

АНУ-ын Дотоодын аюулгүй байдлын яам (DHS)

- Холбооны хамгаалалтын алба (FPS);
- АНУ-ын эргийн хамгаалалт (USCG);
- АНУ-ын эргийн хамгаалалтын цагдаа (CGPD);
- Эргийн хамгаалалтын мөрдөн байцаах алба (CGIS);
- АНУ-ын Гааль ба хил хамгаалах алба (CBP);
- АНУ-ын Цагаачлал, гаалийн хэрэгжилтийн алба (ICE);
- АНУ-ын нууц алба (USSS);

АНУ-ын Тээврийн яам (DOT)

- Холбооны нислэгийн асуудал эрхэлсэн захиргаа (FAA);

Холбооны бусад хууль сахиулах байгууллагууд

- Тагнуулын төв газрын аюулгүй байдлыг хамгаалах алба (CIA SPS);
- Холбооны нөөцийн цагдаа;
- Конгрессийн цагдаагийн газрын номын сан (татан буугдсан 2009);
- Смитсоны үндэсний амьтны хүрээлэнгийн цагдаа;
- АНУ-ын Капитолын цагдаагийн газар (USCP);
- АНУ-ын шуудангийн хяналтын алба (USPIS);
- Ерөнхий байцаагчийн АНУ-ын шуудангийн алба (USPS OIG);
- АНУ-ын ял тэнсэх алба (USPO);
- АНУ-ын Дээд шүүхийн цагдаа.

Дээрх бүтцээс үзэхэд Холбооны хэмжээнд бараг бүхий л яамдад цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой нэгж, алба байдаг байна.

2. Мужийн хууль сахиулах байгууллагын бүтэц

АНУ-ын 50 муж улс нь бүгдээрээ хууль сахиулах байгууллагын тус тусдаа бүтэцтэй. Үүнээс жишээ болгож тус улсын Алабама мужийн хууль сахиулах байгууллагын бүтцийг нарийвчлан авч үзье.

Алабамагийн Хууль сахиулах алба³¹

- Алабама мужийн байгаль хамгаалал, байгалийн нөөцийн газар (Алабамагийн зэрлэг ан амьтан, цэнгэг усны загас агнуурын хэлтэс, хамгаалалтыг хэрэгжүүлэх хэлтэс);
- Алабама дахь Өршөөл үзүүлэх болон тэнсэн суллах зөвлөл;
- Алабама мужийн цэцэрлэгт хүрээлэнгийн байгаль хамгаалагчдын үйлчилгээ;
- Алабама мужийн газрын аюулгүй байдлын алба;
- Алабама дахь ял эдлүүлэх газар;
- Тусгай мөрдөн байцаах товчоо (Алабама сэтгэцийн эрүүл мэндийн цагдаагийн газар);
- Алабама мужийн Үнэт цаасны хороо;
- Алабама мужийн боомтын захиргааны цагдаа;
- Алабама даатгалын газар (Улсын галын маршалын алба);
- Алабамагийн давж заалдах шатны шүүхийн маршалууд;
- Алабама үндэсний гвардийн цэргийн цагдаа / аюулгүй байдлын хүч.

АНУ-д цагдаагийн алба хаагчийн хуваарилалтыг нийтийн удирдлага руу чиглэсэн “Police management”-ээр зохицуулдаг байна. Тодруулбал, тухай бүр цагдаагийн алба хаагчийн нөөц, хотын хэмжээ, гэмт хэргийн гаралт, үндэсний мэдээллийн сүлжээ зэргийг харгалзан хуваарилалт хийдэг байна.³²

АНУ-ын нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлтийг нийт цагдаагийн алба хаагчид (ажил үүргийн онцлогийг харгалзахгүйгээр) тооцож үзвэл:

Дээрх бүтэц, зохион байгуулалтын дагуу 2018 оны байдлаар³³ 100.000 хүн амд ногдох цагдаагийн алба хаагчийн тоо нь 238 байсан бол³⁴ 2019 онд³⁵ нийт 812.000 цагдаагийн алба хаагч ажиллаж байгаа³⁶ бөгөөд үүнийг 100.000 хүн ам тутамд тооцож үзвэл 247 цагдаагийн алба хаагч ногдохоор байна.

Харин мужийн цагдаагийн алба хаагчийн 10.000 хүн амд хамаарах үзүүлэлтийг авч үзвэл хамгийн их нь Вашингтон Ди Си 569, Вилмингтон Дейлвэйр 434, Балтимор Мэйриланд 426 цагдаагийн алба хаагч ногдохоор байгаа бол хамгийн бага нь Вашингтон Саммамиш 52, Мичиган Вейтэрфорд тауншиф 71, Калифорния Индио 71 цагдаагийн алба хаагч ногдохоор байна.³⁷

³¹Alabama Law Enforcement agency <https://www.alea.gov/news-releases>

³² Recruiting and Retaining America's Finest: Evidence-Based Lessons for Police Workforce Planning <https://nij.ojp.gov/library/publications/recruiting-and-retaining-americas-finest-evidence-based-lessons-police>

³³ АНУ-ын нийт хүн амын тоо 2018 оны байдлаар 327.096.265 <https://www.worldometers.info/world-population/us-population/>

³⁴ Full-time Law Enforcement Employees <https://ucr.fbi.gov/crime-in-the-u.s/2018/crime-in-the-u.s.-2018/tables/table-74>

³⁵ АНУ-ын нийт хүн амын тоо 2019 оны байдлаар 329.064.917 <https://www.worldometers.info/world-population/us-population/>

³⁶ 2019 Workforce in US, <https://datausa.io/profile/soc/police-officers#employment>

³⁷ Michael Maciag “How Many Police Officers Does a City Need?”, 2016, <https://www.governing.com/archive/gov-cities-police-officers-hiring.html>

Тав. Оросын Холбооны Улс /цаашид “ОХУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт

ОХУ-ын цагдаагийн байгууллага нь тус улсын Дотоод хэргийн яамны бүтцэд хамаарагддаг. Тус яамны бүтцийг ерөнхийд нь авч үзвэл:³⁸

Ерөнхий газрууд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ерөнхий газар;
- Олон нийтийн аюулгүй байдал, ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийн гүйцэтгэх байгууллагуудын харилцан уялдаа холбоог зохицуулах ерөнхий газар;
- Экстремизмтэй тэмцэх ерөнхий газар;
- Дотоод аюулгүй байдлын ерөнхий газар;
- Тээврийн дэд бүтцийн ерөнхий газар;
- Эрүүгийн байцаан шийтгэх ерөнхий газар;
- Эдийн засгийн аюулгүй байдал, авлигатай тэмцэх ерөнхий газар;
- Шилжилт хөдөлгөөний ерөнхий газар;
- Мансууруулах бодисын хяналтын ерөнхий газар ;

Газар, алба, хэлтсүүд:

- ОХУ-ын дотоод хэргийн яамны Мөрдөн байцаах алба; (MIA-Ministry of Internal Affairs)
- Төрийн үйлчилгээ, боловсон хүчний хэлтэс;
- Иргэн, байгууллагатай албан хэрэг хөтлөлт, хэлтэс;
- Мэдээллийн технологи, харилцаа холбоо, мэдээлэл хамгаалах газар;
- ОХУ-ын Дотоод хэргийн яамны Логистик, эмнэлгийн тусламжийн газар;
- Санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн баталгааны газар;
- Гэрээ ба хуулийн хэлтэс;
- Зохион байгуулалт, дүн шинжилгээний алба.

Үүнээс гадна захиргаа, удирдлагын газар болон сургалт, судалгааны төвүүд үйл ажиллагаа явуудаг.

ОХУ-ын нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын тухайд 2011 оны 2 дугаар сарын 2-нд батлагдсан Цагдаагийн холбооны хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Цагдаагийн байгууллагын бүрэлдэхүүн, цагдаагийн хэсгийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах журмыг ОХУ-ын Ерөнхийлөгч тогтооно"³⁹ гэж заасан бөгөөд тус асуудлыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2011 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн "Цагдаагийн байгууллагын зохион байгуулалтын асуудал" N 250 (2016.12.07-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан) зарлигаар зохицуулж байна.

Цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчийн хуваарилалтыг ОХУ-ын Ерөнхийлөгч зарлиг гаргаж баталдаг. 2016 оны 9 дүгээр сарын 20-ны ОХУ-ын Ерөнхийлөгчийн 480

³⁸“ The ministry of internal affairs of the russian federation structure” <https://en.mvd.ru/structure/Structure>

³⁹“Российская федерация федеральный закон о полиции”, 2011.02.07,

http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_110165/

дугаартай “ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарим актыг өөрчлөх, хүчингүй болгох тухай” зарлигаар цагдаагийн алба хаагчийн орон тоог дараах байдлаар тогтоосон байна.⁴⁰

- ОХУ-ын Дотоод хэргийн яамны төв байгууллагын орон тоог 6,714 байхаар тогтоосон ба үүнд ОХУ-ын дотоод хэргийн байгууллагуудын ажилтнуудыг 6061 хүн, холбооны улсын бусад төрийн албан хаагчид 613 хүний бүрэлдэхүүнтэйгээр, бусад ажилчид 40 байхаар зохион байгуулсан.
- Тухайн холбооны улсын төсвийн хуваарилалтаас санхүүждэг ОХУ-ын дотоод хэргийн байгууллагуудын орон тоог 904.871 хүнээр тогтоосон ба үүнд ОХУ-ын дотоод хэргийн байгууллагуудын 756859 ажилтан, 17199 холбооны бусад төрийн албан хаагч, 130.813 бусад ажилчид байхаар зохион байгуулсан байна.

ОХУ-ын нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлтийг нийт цагдаагийн алба хаагчид (ажил үүргийн онцлогийг харгалзахгүйгээр) тооцож үзвэл:

2016 оны байдлаар ОХУ-ын цагдаагийн алба хаагчийн тоо 756.859⁴¹ байсан ба энэ нь 100.000 хүн амд 515 цагдаа, 1 цагдаагийн алба хаагчид 194 хүн ногдох тоон үзүүлэлттэй байсан байна. Харин 2019 оны эхэн үеийн байдлаар ОХУ-ын цагдаагийн алба хаагчийн тоо 601.000⁴² байсан ба энэ нь 100.000 хүн амд 416 цагдаа, 1 цагдаагийн алба хаагчид 240 хүн ногдохоор байсан бол 2019 оны⁴³ сүүлээр ОХУ-ын цагдаагийн алба хаагчийн тоо 746.000-д хүрч⁴⁴, 1 цагдаагийн алба хаагчид 197 хүн ногдох тоон үзүүлэлттэй болсон ба 100.000 хүн амд 508 цагдаагийн алба хаагч ногдохоор байна.

Зургаа. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /цаашид “ИБУИНВУ” гэх/-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлт

ИБУИНВУ-ын харьяалалд хамаарах Англи болон Уэльсд 43 цагдаагийн хүчин, Умард Ирланд, Шатландад тус бүр 1 цагдаагийн хүчин хамаардаг.⁴⁵

Нутаг дэвсгэрийн цагдаа болон дүүргийн цагдаа, хэсгийн цагдаа гэх мэт хэлтсүүдтэй, ихэнх хэлтсүүд нь дотроо эрүүгийн мөрдөн байцаах тасагтай бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг явуулдаг бол зарим хэлтсүүд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай төрлүүдэд холбогдох тусдаа тасгуудтай байдаг байна. Мөн ихэнх хэлтсүүд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албатай.⁴⁶

⁴⁰ Об изменении и признании утратившими силу некоторых актов Президента Российской Федерации, 2016.09.20, <http://publication.pravo.gov.ru/Document/View/0001201609200003?index=1&rangeSize=2>

⁴¹ Decree of the President of the Russian Federation of September 20, 2016 No. 480 "On amendments and invalidation of certain acts of the President of the Russian Federation"

<http://publication.pravo.gov.ru/Document/View/0001201609200003?index=1&rangeSize=2>

⁴² Россия лидирует по числу полицейских на душу населения, <https://newizv.ru/news/society/28-01-2019/rossiya-lidiruet-po-chislu-politseyskih-na-dushu-naseleniya>

⁴³ ОХУ-ын нийт хүн амын тоо 2019 оны байдлаар 146.075.000

<https://www.statista.com/statistics/263767/total-population-of-russia/>

⁴⁴ Сколько в России нужно полицейских? Версии Германа Грефа и МВД,

<https://www.bbc.com/russian/news-49693323>

⁴⁵ Organisational structure of the police in the UK, <https://www.saferworld.org.uk/downloads/organisational-structure-of-uk-police---saferworld.pdf>

⁴⁶ Мөн тэнд

Цагдаагийн байгууллага нь ерөнхийдөө дараах бүтэцтэй.⁴⁷

1. Ахлах констебл
2. Орлогч
3. Ахлах констеблийн туслах
4. Хүний нөөцийн захирал, Санхүүгийн захирал

Ахлах констеблийн туслахын хариуцдаг байгууллагууд

- Ахлах констеблийн туслахын хотын үйл ажиллагаа (Их Белфаст);
- Ахлах констеблийн туслахын хөдөө орон нутгийн үйл ажиллагаа (бусад улс орон);
- Ахлах констеблийн туслахын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа;
- Ахлах констеблийн туслахын үйл ажиллагааны дэмжлэг (Мэргэшсэн чиг үүрэг, Зэвсэгт хариу арга хэмжээ / Нийтийн хэв журам / Замын хөдөлгөөний салбар);
- Ахлах констеблийн туслахын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх газар;
- Санхүүгийн хэлтэс;
- Хүний нөөцийн хэлтэс;
- Хууль зүйн үйлчилгээний хэлтэс;
- Хэвлэл мэдээлэл ба PR-ийн хэлтэс.

ИБУИНВУ-ын томоохон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагууд:⁴⁸

- Манчестерийн цагдаагийн газар;
- Баруун Йоркширийн цагдаагийн газар;
- Вэст Мидлэндийн цагдаагийн газар;
- Шотландын цагдаагийн газар;
- Лондон хотын цагдаагийн газар;
- Умард Ирландын цагдаагийн алба.

Мөн цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын хувьд Лондонгийн цагдаагийн газарт 28.000 цагдаагийн алба хаагч байх шаардлагыг тавьдаг бол бусад жижиг хотын цагдаагийн газарт 700-800 цагдаагийн алба хаагч байхыг шаарддаг.⁴⁹ ИБУИНВУ-ын Цагдаагийн болон гэмт хэргийн тухай хуульд цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын талаар зохицуулаагүй байдаг⁵⁰.

ИБУИНВУ-ын нэг цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон үзүүлэлтийг нийт цагдаагийн алба хаагчид (ажил үүргийн онцлогийг харгалзахгүйгээр) тооцож үзвэл:

2019 оны⁵¹ байдлаар нийт цагдаагийн алба хаагчийн тоо 124.784⁵² байсан ба энэ нь 100.000 хүн тутамд 185 цагдаагийн алба хаагч, 1 цагдаагийн алба хаагчид 541 хүн ногдож байна. Харин 2020 оны⁵³ байдлаар нийт цагдаагийн алба хаагчийн тоо нь 158.772⁵⁴ хүрсэн ба

⁴⁷ Мөн тэнд

⁴⁸ Мөн тэнд

⁴⁹ Мөн тэнд

⁵⁰ Policing and Crime act 2017 <https://www.legislation.gov.uk/ukpga/2017/3/contents/enacted>

⁵¹ ИБУИНВУ-ын нийт хүн амын тоо 2019 оны байдлаар 67,530,172

<https://www.macrotrends.net/countries/GBR/united-kingdom/population>

⁵² "Police workforce, England and Wales, as at 30 September 2019" (PDF). Home Office. Retrieved 30 March 2020, <https://www.gov.uk/government/statistics/police-workforce-england-and-wales-30-september-2019>

⁵³ ИБУИНВУ-ын нийт хүн амын тоо 2019 оны байдлаар ИБУИНВУ-ын нийт хүн амын тоо 2019 оны байдлаар 66,796,807 <https://www.macrotrends.net/countries/GBR/united-kingdom/population>

энэхүү үзүүлэлт нь 100.000 хүн ам тутамд 234 цагдаагийн алба хаагч ногдох, 1 цагдаагийн алба хаагчид 428 хүн ногдохоор байгаа юм.

ИБУИНВУ-ын цагдаагийн байгууллагуудаас хамгийн их цагдаагийн алба хаагчтай газар нь Лондон хотын цагдаагийн газар 32.958, Шотландын цагдаагийн газар 17431, Умард Ирландын цагдаагийн газар 6917, Баруун Мидландын цагдаагийн газар 6516, Баруун Иоркширегийн цагдаагийн газар 5342, Теймс Уоллейгийн цагдаагийн газар 4310 цагдаагийн алба хаагчтай гэх зэргээр тэргүүлдэг бол Дюрхеймийн цагдаагийн газар 1141, Линколнширегийн цагдаагийн газар 1067, Варвикширегийн цагдаагийн газар 1035, Вильтширегийн цагдаагийн газар 1007 цагдаагийн алба хаагчтай зэргээр хамгийн бага цагдаагийн алба хаагч ажилладаг байна.⁵⁵

Дээрх судалгаанд үндэслэн улс орнуудын тоон үзүүлэлтийг харьцуулан үзвэл:

Хүснэгт 3. Нийт хүн амын тоог цагдаагийн алба хаагчид харьцуулсан тоон үзүүлэлт

	Цагдаагийн алба хаагчийн тоо	Нийт хүн амын тоо	100.000 хүн амд ногдох цагдаагийн алба хаагчийн тоо	Нэг цагдаагийн алба хаагчид ногдож буй хүн амын тоо	Зохицуулж буй хэлбэр
хамгийн сүүлийн оны судалгаагаар					
Монгол Улс	10.170	3.357.542	303	330	- Цагдаагийн албаны тухай хууль (ерөнхий зохицуулсан), - Захиргааны хэм хэмжээний акт буюу журам
Бүгд Найрамдах Солонгос Улс	122.913	51.225.308	238	421	- Цагдаагийн тухай хууль (ерөнхий зохицуулсан), - эрх зүйн акт шийдвэр
Оросын Холбооны Улс	746.000	146.750.000	508	197	- Цагдаагийн тухай хууль (ерөнхий зохицуулсан), - Ерөнхийлөгчийн зарлигаар
Америкийн Нэгдсэн Улс	812.000	329.064.917	247	404	- Police management-ийн талаар тушаал, шийдвэр

⁵⁴ Number of police officers in the United Kingdom (UK) in 2020 by police force, <https://www.statista.com/statistics/877540/leading-police-forces-by-officer-numbers-in-the-uk/?fbclid=IwAR2Ih9TLkfRokgGJTp6bX8LUlenO82uKbm1LMM-DaLqJKvMnpR4vOWtZW08>

⁵⁵ Number of police officers in the United Kingdom (UK) in 2020 by police force, <https://www.statista.com/statistics/877540/leading-police-forces-by-officer-numbers-in-the-uk/?fbclid=IwAR2Ih9TLkfRokgGJTp6bX8LUlenO82uKbm1LMM-DaLqJKvMnpR4vOWtZW08>

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	158.772	67.886.011	234	428	- Тухай бүр гарсан тушаал, шийдвэрийн дагуу
--	---------	------------	-----	-----	---

Дээрх үзүүлэлтийг дүгнэж үзвэл, цагдаагийн алба хаагчид хамгийн бага хүн ам ногддог, цагдаагийн алба хаагч ихтэй улс нь ОХУ байгаа бол хамгийн их хүн ам ногддог, цагдаагийн алба хаагч багатай улс нь БНСУ байна. Харин МУ-ын тухайд хүн ам хийгээд цагдаагийн алба хаагчаараа хамгийн бага байгаа хэдий ч эдгээр улсуудтай харьцуулахад хүн ам, цагдаагийн алба хаагчийн тоон харьцаагаар дундаж үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

Харьцуулсан судалгаагаар МУ, БНСУ, ОХУ, АНУ, ИБУИНВУ-ын цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, цагдаагийн алба хаагчид ногдох хүн амын тоон харьцааг гаргаж ирэхийг хичээлээ.

Цагдаагийн алба хаагчдын хуваарилалтын талаар улс орнуудын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсныг судлах явцад сонгож авсан гадаадын 4 улсад цагдаагийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний талаар манай улсын Цагдаагийн албаны тухай хуульд тусгасны нэгэн адил ерөнхий байдлаар зохицуулжээ. Гэвч яг манай улсын Засгийн газрын тогтоолоор хүн амын тоотой харьцуулан хуваарилалт, норм баталсан эрх зүйн баримт бичиг судалгааны явцад тогтоогдсонгүй.

Харин олон улсын зохицуулалтад тухайн асуудлаар нарийвчилсан стандарт байдаггүй ба олон улсын байгууллагаас хийсэн судалгаа, зөвлөмж зэрэг байна.

Цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын хувьд улс, орон бүр өөр өөрийн гэсэн зохицуулалттай байна. Олон улсын эрх зүйн баримт бичгийн хувьд цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын талаар ямар нэг стандартыг тогтоосон баримт бичиг судалгааны явцад тогтоогдоогүй бөгөөд олон улсын байгууллагуудаас хийсэн судалгааны тайланд энэ талаар дурдагдсан байна. Тухайлбал, ICMA буюу Олон улсын хот төлөвлөлтийн холбооны судалгаанаас харахад цагдаагийн алба хаагчийн хуваарилалтыг хэрхэн хийх аргыг авч үзсэн бөгөөд ингэхдээ хуваарилалт хийдэг 5 арга байдаг талаар дурдсан ба тухайн аргуудыг үр дүнтэй, үр дүнгүй эсэхэд дүгнэлт өгсөн байна. Эдгээр аргын талаар өгсөн дүгнэлтүүдийг нэгтгэн харвал, 1/гэмт хэргийн чиг хандлагаар хуваарилах арга нь ховорхон хэрэглэгддэг, оновчтой биш, 2/нэг хүнд ногдох цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын арга нь найдваргүй, үр ашиггүй, 3/хамгийн бага ажиллах түвшингээр хуваарилах арга нь хүндрэлтэй, 4/төсөв болон эрх олголтод суурилсан арга нь олон нийтийн бодит хэрэгцээг тусгадаггүй, 5/бодит ажлын ачаалалд суурилсан арга нь үр дүнтэй хэдий ч мэдээллийн цогц систем шаарддаг гэжээ.

Монгол Улсын хувьд Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын хавсралт “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг баталж, зохицуулж байгаа нь хоёрдугаар арга буюу нэг хүнд ногдох цагдаагийн алба хаагчийн хуваарилалтын аргыг хэрэглэж байгаатай төстэй байна. Гэвч энэхүү аргыг ICMA-ийн судалгаанд найдваргүй, үр ашиггүй талаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, жилийн жилд цагдаагийн албан хаагч дутмаг, ажлын ачаалал их байгаа талаар яригддаг нь энэхүү хуваарилалтын арга буруу байгаатай холбоотой байж болох юм. Иймд дээрх 5 аргаас хамгийн үр дүнтэй арга буюу бодит ажлын ачаалалд суурилсан хуваарилалтын аргыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ашигласан эх сурвалж

Нэг. Засгийн газрын тогтоол

- Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолын хавсралт “Цагдаагийн байгууллагын зарим ажил,үйлчилгээ, хангалтын жишиг норматив”;
- Засгийн газрын 2017 оны “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 76 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 141 дугаартай тогтоолын хавсралт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”.

Хоёр. Цахим эх сурвалж

- <https://www.legalinfo.mn>
- <http://eagle.mn>
- <http://sukhbaatar-2.police.gov.mn>
- <http://ubstat.mn>
- <https://montsame.mn>
- <https://www.1212.mn>
- <https://www.ipa-international.org>
- <https://icma.org>
- <https://www.unodc.org>
- <https://www.landbridge.mn>
- <https://www.police.go.kr>
- <https://www.law.go.kr>
- <https://www.macrotrends.net>
- <https://www.statista.com>
- <https://www.discoverpolicing.org>
- <https://www.alea.gov>
- <https://nij.ojp.gov>
- <https://www.worldometers.info>
- <https://ucr.fbi.gov>
- <https://datausa.io>
- <https://www.governing.com>
- <http://www.consultant.ru>
- <http://publication.pravo.gov.ru>
- <https://newizv.ru>
- <https://www.statista.com>
- <https://www.bbc.com>
- <https://www.saferworld.org.uk>
- <https://www.legislation.gov.uk>
- <https://www.macrotrends.net>
- <https://www.gov.uk>